



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2013 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/262

Улаанбаатар хот

Тээврийн хэрэгсэл бүртгэн авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, 78 дугаар зүйлийн 78.2.1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 3.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Дүүргийн төсвийн хөрөнгөөр худалдан авсан 135,800,000 (нэг зуун гучин таван сая найман зуун мянга) төгрөгийн үнэ бүхий, хавсралтад заасан тээврийн хэрэгслийг нийслэлийн өмчид бүртгэн авсугай.

2. Хавсралтад заасан тээврийн хэрэгслийг бүртгэн авч, ашиглалт, хамгаалалтыг хариуцан ажиллахыг Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар (П.Баянбаатар)-т үүрэг болгосугай.

3. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (Ч.Сайханбаяр)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

Д.СУМЪЯАБАЗАР



1110201106

Нийслэлийн Засаг даргын 2023 оны
03 сарын 27-ны өдрийн
А.Э.В. дугаар захирамжийн
хавсралт



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД БҮРТГЭН АВАХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр	Марк	Арлын дугаар	Улсын дугаар	Үйлдвэрлэсэн он	Бүртгэх үнэ /төгрөгөөр/	Эх үүсвэр	Эзэмшигч байгууллагын нэр
1	Суудлын машин	Toyota Alphard-H20	АНН258053562	10-22 УБҮ	2014	67,600,000	Төсөв	Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар
2	Суудлын машин	Toyota Alphard-H20	АТН208046747	12-83 УБҮ	2014	67,800,000	Төсөв	Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар
Дүн						135,400,000		